



ӨМНӨГОВЬ АЙМАГ
НОМГОН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 09

Сангийндалай

┌ Хөрөнгө актлах, саналыг уламжлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77,1 дэх хэсэг, "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 6.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ном-Дизель ОНӨААТҮГ-ын 15 нэр төрлийн 2739900 \Хоёр сая долоон зуун гучин есөн мянга есөн зуу\ төгрөгийн хөрөнгийг нэгдүгээр, Эрүүл мэндийн төвийн 44 нэр төрлийн 15369154 \арван таван сая гурван зуун жаран есөн мянга нэг зуун тавин дөрөв\ төгрөгийн хөрөнгийг хоёрдугаар, Ерөнхий боловсролын сургуулийн 66 нэр төрлийн 25651140 / хорин таван сая зургаан зуун тавин нэгэн мянга нэг зуун дөч /төгрөгийн хөрөнгийг гуравдугаар, 14 дүгээр цэцэрлэгийн 10 нэр төрлийн 6861 021 \Зургаан сая найман зуун жаран нэгэн мянга хорин нэг\ төгрөгийн хөрөнгийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус акталсугай.

2. Эрүүл мэндийн төвийн 30000000 \гучин сая\ төгрөгийн тээврийн хэрэгсэл, Засаг даргын тамгын газрын 5750000 \Таван сая долоон зуун тавин мянган\ төгрөгийн тээврийн хэрэгслүүдийг актлах саналыг аймгийн орон нутгийн өмчийн газарт уламжилсугай.

3. Шийдвэрийг аймгийн орон нутгийн Өмчийн газарт хүргүүлж, журмын дагуу устгах, худалдах ажлыг иргэдэд ил тод, нээлттэй зохион байгуулж, байгууллагуудын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллахыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөл \Э.Тайванжаргал\-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Н.БУЯНХИШИГ



Data D:/itht2020/ togtool Adoc